

“ESG FINANCE” JSC

“И Эс Жи Файнанс” ХК

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН

ТОГТООЛ

2026 оны 3 сарын 18 өдөр

Дугаар: 26/01/02

Улаанбаатар хот

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 59.4 дэх заалт, 60 дугаар зүйл, 64.2 дахь заалт, Санхүүгийн Зохицуулах Хорооноос баталсан Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт тавих журмын 2.1 , 2.3 дахь заалтууд, компанийн дүрмийн холбогдох заалтуудыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “И Эс Жи Файнэнс” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2026 оны 4-р сарын 30-ны өдрийн 12 цагт Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 1-р хороо, Худалдааны гудамж, Дельта төвийн 5-р давхарт 502 тоот өрөөнд хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2026 оны 4-р сарын 10-ны өдрөөр тогтоосугай.
3. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дор дурдсан асуудлыг хэлэцүүлэхээр баталсугай. Үүнд:
 1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах
 2. Компанийн 2026 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах
 3. Компаний дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах
 4. Нэмэлт хувьцаа гаргах
 5. Ногдол ашиг хувиарлах эсэх тухай тайлагнах
 6. “Жи эф жи файнэнс” ХХК, “Жи эф жи иншүрэнс” ХХК-ийн үүсгэн байгуулагчаас хасагдах тухай
 7. Бусад.
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг 2026 оны 3-р сарын 23-нд өдөр тутмын сонин, радио телевизийн аль нэгээр болон МХБ-ийн сайтаар; 2026 оны 4-р сарын 10-нд уг зарыг давтан, 2026 оны 3-р сарын 28-ны дотор брокерийн компаниудаар дамжуулан хувьцаа эзэмшигчдэд мэдээлсүгэй.
5. Санал хураах хуудсыг хүлээн авах эцсийн хугацааг 2026 оны 4-р сарын 28-ны өдрийн 10 цагаар тасалбар болгосугай.
6. Ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс хурлаар хэлэлцэх асуудлаар санал авах “Саналын хуудас”-ны агуулгыг Хавсралт 1-р, хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийн жагсаалтыг Хавсралт 2-р, хурлын дэгийг Хавсралт 3-р тус тус баталсугай.

7. Хурлаар хэлэлцүүлэх асуудалтай холбоотой танилцуулга, хурлаас гарах шийдвэрийн төслийг 2026 оны 4-р сарын 02 өдөр гэхэд бэлэн болгож, хувьцаа эзэмшигчдийн хурлыг зохион байгуулахыг хурал зохион байгуулах комисс / М.Сайнболор/-т даалгасугай.
8. Хурлын зарыг хувьцаа эзэмшигчдэд хүргэхтэй холбогдон гарах зардлыг компаниас гаргуулсугай.
9. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Хурал зохион байгуулах комиссын дарга: М.Сайнболор, гишүүн: Г.Оюунболд, Тооллогын комиссийн дарга: Д.Чулуунбаатар, гишүүнээр Д.Бямбасүрэн нарыг тус тус томилсугай.
10. “И Эс Жи Файнэнс” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдлийг Санхүүгийн Зохицуулах Хороо, “Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК-д хүргүүлэхийг хурал зохион байгуулах комисст даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Р.ОТГОНБАТ